



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.3, 6.4.4, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Ховд-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 11 нэрийн, нийт 21,455,200.00 (хорин нэгэн сая дөрвөн зуун тавин таван мянга хоёр зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.“Ховд-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Батцагаанд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2022
оны 01 дүгээр сарын 10-ны
өдрийн 10/10 дугаар
тогтоолын хавсралт

**"Ховд-АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж данснаас хасах
хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	үйлдвэрлэсэн/а шиглалтад орсон огноо	Тоо хэм жээ	Балансын үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	30км-т барих гар	9/1/2012	1	320,000.00	320,000.00	0
2	5 ханатай иж	1/1/2007	1	814,100.00	814,100.00	0
3	5 тн битум агуулах ёмкость	1/1/2007	1	1,123,300.00	1,123,300.00	0
4	8 тн-н төмөр бул	1/1/2007	1	3,174,600.00	3,174,600.00	0
5	Бетон зуурагч	1/1/2007	1	1,786,300.00	1,786,300.00	0
6	Дизель станц /60 мотор/	1/1/2006	1	6,369,200.00	6,369,200.00	0
7	Зуурмагийн	12/1/2012	1	104,300.00	104,300.00	0
8	НШ-5 бага оврын бутлагч	1/1/2005	1	5,211,500.00	5,211,500.00	0
9	Хэмжих багаж	12/1/2011	1	1,290,000.00	1,290,000.00	0
10	Шатхууны	1/1/2007	1	805,900.00	805,900.00	0
11	Байршил тогтоогч	10/1/2012	1	456,000.00	456,000.00	0
			11	21,455,200.00	21,455,200.00	0
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		11 (арван нэг)	21,455,200.00 (хорин нэгэн сая дөрвөн зуун тавин таван мянга хоёр зуун)	21,455,200.00 (хорин нэгэн сая дөрвөн зуун тавин таван мянга хоёр зуун)	